



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/107

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Нэгдсэн эмнэлгийн лифт, хүлээн авахын хэсгийн засвар, тоноглол (Булган сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Оакс экспресс монголиа” ХХК-тай 398,708,221 (гурван зуун ерэн найман сая долоон зуун найман мянга хоёр зуун хорин нэг) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Нэгдсэн эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Бүрэндондов)-д үүрэг болгосугай.

4.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Оакс экспресс монголиа” ХХК-ийн захирал (Ц.Энхжин)-д даалгасугай.

5.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.


6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 18-ний өдрийн 4/007 дугаар
захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

№	Нөхцөл шаардлага	Барилгын ажил	Лифт-1	Лифт-2	Нийт	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	1,530,971	2,650,532	2,397,907	6,579,410	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	1,530,971	2,650,532	2,397,907	6,579,410	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	765,486	1,325,266	1,198,953	3,289,705	Ү.Бямбасүрэн
4	Нормчлолын сан	137,787	238,548	215,812	592,147	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	19,800,000				Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.				Д.Батцогт
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.				Д.Батцогт Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувь				Д.Батцогт
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 120 хоног				Ү.Бямбасүрэн